

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**  
2016/01/22

*2015 оны жилийн эцсийн байдлаар*

№	Зорилт	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2015 онд хүрэх түвшин	Төсөө зарцуулалт	Хэрэгжилт	Яамны үнэлгээ	ЗГХЭГ үнэлгээ	Тайлбар	
<b>НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>										
<b>Зорилт 2.Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.</b>										
2.2	ҮХЦБ-ын "Ажилтай, орлоготой Монгол Үндэсний хөтөлбөрийн дахь заалт	4.8, хүн" 3.3	Эдийн засгийн салбаруудын ажиллах хүчний төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах	Ажиллах хүчний хэтийн тооцооллыг хэрэгжүүлэх салбарын тоо	4-өөс доошгүй салбар	-	Уул уурхайн салбарын ажиллах хүчний төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах ажлын хүрээнд шинээр ашиглалтад ороход бэлэн болсон 43 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрт улсын комисс ажиллан хүлээн авч байнгын ашиглалтад оруулсан. Үүний үр дүнд шинээр 5342 ажлын байр нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.	100		БХЗГ
<b>Зорилт 4.Гадаад худалдааны бодлогоор дамжуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтална.</b>										
4.1	ЗГҮАХХАХТ-ний 41.1 дэх заалт.	Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх	Нэг цонхны бодлого хэрэгжих ажлын явц, хувь	100 хувь	-	Уул уурхайн сайдын 2013 оны 11-р сарын 18-ны өдрийн 240 дугаар тушаалаар экспортын нэг цонхны зарчмаар үйл ажиллагаа явуулах, эрдэс бүтээгдэхүүнд баримтлах жишиг үнийг тогтоож буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уул уурхайн сайдын 2013 оны 7-р сарын 05-ны өдрийн 153 дугаар тушаалаар Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэс баялгийн бүтээгдэхүүний бирж байгуулах, түүнчлэн экспортын нэг цонхны зарчмаар үйл ажиллагаа явуулах, хууль зүйн орчин бүрдүүлэх тухай санал, дүгнэлт, гаргах шийдвэрийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг санал дүгнэлтийн эхний хувилбарыг боловсруулсан. Стратегийн ач холбогдол бүхий ордын 10 хувьд ноогдох хувьцааг дотоодын хөрөнгийн биржээр борлуулах асуудлыг судлаж байна. Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төсөл, Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулаад байна. Эрдэс	90		СБТГ	

						баялгийн биржийн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулж, уг үзэл баримтлалд үндэслэсэн хуулийн төслийг боловсруулан ЗГХЭГ-ын зөвлөмж болон яамдын саналыг тусган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлэн болгоод байна. Уг хуулийн төсөл батлагдсанаар ашигт малтмалын экспортыг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэх юм.			
--	--	--	--	--	--	--	--	--	--

**ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО**

**Зорилт 9.Уул уурхайн салбарыг дэмжих чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.**

9.2	ЗГҮАХХАХТ-ний 7 дахь заалт	Экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн биржийн эрх зүйн орчныг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжит, хувиар	100 хувь	0.2 Улсын төсөв	Австрали, Индонези, Япон, БНСУ, БНХАУ зэрэг Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай уул уурхайн бүтээгдэхүүний чиглэлээр бүс нутгийн интеграцийг бий болгох, экспортын бодлогын зохицуулалтын загвар төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж ажилласан. Төмөр, жонш зэрэг бүтээгдэхүүний экспортын талаар холбогдох судалгааг хийж, Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоолоор “Ангилал, стандарт, зах зээлийн үнийн эх сурвалжийг батлуулсан. Мөн эрдэс баялгийн экспортын талаар холбогдох судалгаа хийж санал боловсруулсан. СЯ, ҮХААЯ болон ТатЕГ, ГЕГ, АМГ-уудын төлөөллийг багтаасан Нүүрс, төмөр, жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний шинж чанар, боловсруулалтын түвшингээр нарийвчилсан судалгааг хийж, олон улсын жишигт нийцсэн ангилал, стандартыг тогтоох санал боловсруулах, үүрэг бүхий Ажлын хэсгийг УУС-ын 73 дугаар тушаалаар байгуулж Ажлын хэсгийн хүрээнд голлох түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийг судалж, уул уурхайн бүтээгдэхүүний жишиг үнийг тогтоох ажлын хэсгийг сар бүр хуралдуулсан. Нүүрс, алт, төмөр болон бусад ашигт малтмалын баримтлах жишиг үнийг нэгтгэсэн. Жишиг үнийг тогтоож Уул уурхайн яамны вэб сайтад байршуулж олон нийтэд мэдээлж байна. УУС-ын 2013 оны 240 дүгээр тушаалаар экспортын нэг цонхны зарчмаар үйл ажиллагаа явуулах, эрдсийн бүтээгдэхүүнд баримтлах жишиг үнийг тогтоож буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Төрөөс эрдэс	90		СБТГ
-----	----------------------------	--	----------------------------------	----------	-----------------	---	----	--	------

					<p>баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт эрдэс түүхий эдийн бирж байгуулах асуудлыг мөн тусгасан. Эрдэс баялгийн биржийг байгуулах талаар Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /GIZ/-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн хүрээнд 2013 онд Хамтран ажиллах санамж бичиг байгуулан судалгаа, шинжилгээг хийсэн. Түүнчлэн УУС-ын 2013 оны 153 тоот тушаалаар дэд сайдаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн зарим гишүүд туршлага судлах ажлын хүрээнд зарим орны биржийн үйл ажиллагаатай танилцаж, хууль зүйн орчны тогтолцоо, арилжааны төрөл хэлбэр зэргийг харьцуулан судалж, хамтын ажиллагааг эхлүүлж, харилцан мэдээлэл солилцсон. Тус биржийг байгуулахдаа 100 хувь хувийн хэвшлийн хөрөнгөөр гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн түншлэлд тулгуурлан үйл ажиллагаа явуулахаар тусгасан. 2014 оны 6 дугаар сарын 28-ны Засгийн газрын 211 дүгээр тогтоолоор Эрдэс баялгийн бирж байгуулахтай холбогдуулж түүний үйл ажиллагааны журам, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг 9 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулах шийдвэр гарсан. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт тусгасан эрдэс баялгийн бирж байгуулах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, үйл ажиллагааг зохицуулах журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг Уул уурхайн сайдын 2014 оны 177 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд журам, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг боловсруулж Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид санал авахаар хүргүүлж зарчмын хувьд дэмжсэн. Дээрх баримт бичгийн төслүүдийг холбогдох байгууллагуудын саналыг тусган Монгол Улсын Засгийн Газрын хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл, холбогдох танилцуулгыг 2014 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн 1/2306 тоотой ЗГХЭГ-т хүргүүлсэн. Эрдэс баялагийн биржийн тухай хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалыг боловсруулаад байна.</p>			
--	--	--	--	--	--	--	--	--

9.3	ҮХЦБ-ын 5.2.1.1, ЗГҮАХХАХТ-ний 38 дахь заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийж гүйцэтгэх	Нийт хамруулах газар нутгийн хэмжээ, хувь	36 хувь	15.0 Улсын төсөв	<p>2015 онд үргэлжилж буй 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 40 төслийн төсөв, төлөвлөгөөг Уул уурхайн сайдын 2015 оны 33 дугаар тушаалаар батлуулсан.</p> <p>2011-2014 онд хэрэгжиж дууссан 7 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж, Уул уурхайн сайдын 2015 оны 13, 38-42, 121 дүгээр тушаалаар хүлээн авч шийдвэрлэсэнээр нийт газар нутгийн 33 хувийг хамруулсан байна. Төслүүдийн 2015 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.</p> <p>Төслүүдийн 2015 оны хээрийн судалгааны ажлын материалыг хүлээн авсан. Мөн төслүүдийн 2015 оны хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг хийж зөвлөмж өгсөн.</p> <p>1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийж гүйцэтгэх ажлын гадаад орнуудтай хамтран ажиллах зорилтын хүрээнд:</p> <p>-БНПольш Улсын Геологийн албатай хамтран “Хасагт” төслийн үр дүнгийн тайланг 2015 оны 6-р сар хүртэл боловсруулах хугацааг сунгасан талаар АМГ-т чиглэл хүргүүлсэн.</p> <p>-БНЧехУлсын Геологийн албатай хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Алтай-50” 1:50000-ны масштабын ГЗЕЭ-ийн ажлыг хамтарсан төслийн 2015 оны төсөв, төлөвлөгөөг УУС-ын 2015 оны 33 дугаар тушаалаар батлуулсан.</p> <p>-Австрали Улсын Геологийн албатай (Geoscience Australia project) энэ төрлийн ажлыг хийхэд орчин үеийн техник технологи, шинжлэх ухааны шинэлэг арга, аргачлалыг нэвтрүүлэх боломжийн талаар санал солилцон хамтран ажиллахаар болсон. Төслүүд үргэлжлэн хэрэгжиж байна.</p>	90		СБТГ
9.4	ЗГҮАХХАХТ-ний 99 дэх заалт, Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого 3.3.2 дахь заалт	Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Үйлдвэрийн барилгын ажил эхэлсэн байна.	Хувийн хөрөнгөөр	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр улсын төсөвт суулгасан 1,45 тэрбум төгрөгөөр газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг хүргүүлсэн. Д-ГТБҮ-ийн Техникийн зураг төслийн ажил (ТЗТА)-ыг гүйцэтгэх болон уг ажлын төлбөрийн тухай Уул уурхайн яам, “Д-ГТБҮ” компани, японы талаас Тоёо инженеринг корпорацийн хооронд 2013 оны 5 дугаар сард байгуулсан гэрээний дагуу Тоёо инженеринг	70		ТБЗГ

					<p>корпораци Техникийн зураг төслийг (7 боть, 9000 хуудас, 700 зураг схем) боловсруулж 2013 оны 11 дүгээр сард “Д-ГТБҮ” ХХК-д ирүүлсэн. Техникийн зураг төслийн ажлыг боловсруулсны дараа хөрөнгө оруулалтын зардал өмнө төсөвлөж байснаас 2 дахин нэмэгдсэн тул Тоёо инженеринг корпораци тус үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэх боломжгүй гэдгээ 2014 оны дундуур төслийн ерөнхий зохицуулагч Марубени корпорацид мэдэгдсэн. Иймээс Марубени корпораци Дарханы үйлдвэрийг барих асуудлыг японы Чиёда корпорацид тавьж уг асуудлаар тохиролцоонд хүрсэн байна. Чиёда корпораци нь Тоёо инженеринг корпорацийн хийсэн Техникийн зураг төслийн ажлыг өөрсдийн тооцоо судалгаанд үндэслэн шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзсэн.</p> <p>ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төр, хувийн эзэмшлийн оролцоотой боловсруулах үйлдвэр барьж, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой болгох зорилт тусгагдсан ба 2013 оны 5 дугаар сард Засгийн газраас “Д-ГТБҮ” ХХК-ийн төрийн өмчийн оролцооны хувь хэмжээг 51 хувиар тогтоох тухай 171 дүгээр тогтоол гаргасан. Мөн “NTT групп” ХХК, ХБНГУ-ын "Ferrostaal", БНЧУ-ын "Vae Controls" компаниуд нэгдэн байгуулсан “NTT” консорциумаас гаргасан төрийн оролцоо бүхий үйлдвэр байгуулах саналыг дэмжин ажиллаж байна.</p> <p>2014 оны 3-р сарын 17-нд ҮАБЗ-өөс дотоодын эх үүсвэрийг түшиглэн шийдэх зөвлөмж гарсан тул Дархан газрын тос боловсруулах үйлдвэрийн байршил болон төслийг бүхэлд нь дахин төлөвлөхөөр болсон.</p> <p>ЗГ-ын 2015 оны 3 сарын 23-ны №113 тогтоол гарч боловсруулах үйлдвэр байгуулах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардлагатай зардлыг санхүүжүүлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгасан.</p> <p>ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнийг баталсан УИХ-ын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэрийн</p>			
--	--	--	--	--	--	--	--	--

						асуудал Аж үйлдвэрийн яаманд хамаарч байна. /Биелэлт 70%/			
9.5	ҮХЦБ-ын 5.2.1.1 дэх заалт	Нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Туршилтын үйлдвэр ашиглалтад орсон байна.	Зээлийн хөрөнгө өр	Монгол Улс уул уурхайн салбарын үйлдвэрлэлд Японы дэвшилтэт, байгаль орчинд ээлтэй техник технологийг ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд Японы улсын дэмжлэгийг авч, харилцан ашигтай хамтран ажиллах чиглэлийг баримталж ажиллаж ирсэн. Өнгөрсөн оны 12 дугаар сард Японы Шинэ эрчим хүчний байгууллага-(NEDO)-ын захиалгаар Монгол Улсад хүрэн нүүрс боловсруулж хагас коксон шахмал түлш үйлдвэрлэх, хуурай аргаар нүүрс баяжуулах технологийг Монгол Улсад нэвтрүүлэх төслүүд хэрэгжүүлэх тухай тендер зарлаж тендерийн гүйцэтгэгч байгууллагууд Япон улсын талаас шалгараад байгаа билээ. Одоогоор төслийн судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд Японы Шинэ эрчим хүчний байгууллага (NEDO)-оос ирүүлсэн Уул уурхайн яамтай хамтран байгуулах Санамж бичгийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, чиглэл авсан. Энэхүү Санамж бичгийг байгуулсанаар Монгол улсад хуурай аргаар нүүрс баяжуулах туршилтын үйлдвэр барих үндэс тавигдах юм. /Биелэлт 50%/	50		ТБЗГ

## УУЛ УУРХАЙН ЯАМНЫ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР